

1

ХҮН АМ БА ХӨГЖИЛ

А.СОЛОНГО

Эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт хоёрын хооронд нарийн түвэгтэй, уялдаа холбоо байгааг МЭӨ 1300 оноос хүн ам, хөгжлийн асуудлаархи номлол, үзэл баримтлал, онолуудад тайлбарласаар иржээ. Гэхдээ энэ хоёр хувьсагч нь нэг нь нэгнийхээ учир шалтгаан болохгүйгээр хоорондоо уялддаг байж болох юм. Монголын хүн амын өсөлт нь эдийн засгийн өсөлтөнд түлхэц болж байна уу? эсвэл хүн амын өсөлтийн бууралт нь эдийн засгийн өсөлтөнд саад учруулж байна уу? гэх мэтийн асуултуудад бид хариулт шаарддаг. Тэр дундаа өргөн уудам нутаг дэвсгэрт жигд бус тархан байршсан, цөөн хүн амтай манай улсын хувьд хөгжлийн гол түлхүүрийг хүн амын өсөлт гэж үзэж, тайлбарлах хандлага өндөр байдаг. Сүүлийн 10 гаруйхан жилийн хугацаанд хүн амын төрөлтийн огцом бууралтын нөлөөгөөр хүн амын насны бүтцэд ихээхэн өөрчлөлт гарч байгаа тул энэхүү хэлэлцүүлгийг эрхэм уншигч тантай хуваалцахыг зорьсон билээ.

Хүн амын өсөлт эдийн засгийн хөгжлийн хөшүүрэг мөн үү?

Хүн амын өсөлт эдийн засгийн хөгжлийг дэмжин түлхэц өгдөг гэсэн анхны санааг Данийн эдийн засагч Эстер Босрап дэвшүүлсэн бөгөөд XVIII зууны Европын аж үйлдвэрийн хувьсгал болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлтийг дагалдан Европын хүн ам өссөн түүх үүнийг гэрчилдэг. Гэхдээ түүний үзлийн гол санаа нь хөдөө аж ахуйн хувьсгалтай холбоотой гарч иржээ. Тухайн үеийн Европ, АНУ-д явагдсан хөгжилд хүн амын өсөлт гол хөшүүрэг болсон байна. Зарим түүхчид Европод аж үйлдвэржилтийн өмнө халдварт тахлыг бүрмөсөн устгаснаар нийтийг хамарсан нас баралт буурсан явдал “Аж үйлдвэрийн хувьсгалын оч”-ийг бадраасан гэж үздэг.

Аж үйлдвэржсэн өндөр хөгжилтэй улс орнуудын хөгжилд хүн амын өсөлт дэм болсон гэдгийг хөгжлийн түүх илтгэж байгаа боловч өнөөгийн хөгжингүй орнуудтай харьцуулахад ялгаатай гэдгийг хөгжлийн олон үзүүлэлт харуулж байна. Тухайлбал, өнөөдөр хөгжил дорой улс орнууд ерөнхийдөө хөгжингүй улс орнуудын 200 гаруй жилийн хугацаанд туулсан хөгжлийн замыг давтахгүй байгаа юм.

Өндөр хөгжилтэй улс орнуудын хөгжлийн амжилтыг импортлох замаар хөгжил дорой улсууд хүн ам зүйн шилжилтийн¹ үе шатуудад ердөө 30-50 жилийн хугацаа зарцуулж байна.


Хүн амын өсөлт болон эдийн засгийн хоорондын харилцаа нь тухайн улс орны дамжин өнгөрч буй хүн амын зүйн шилжилтийн ямар үе шатанд байгаагаас ихэвчлэн хамааран өөрчлөгдөж байдаг. Ажиллах хүчний нийлүүлэлт буюу хангамж талаас авч үзвэл эдийн засгийн хөгжилд чухам аль насны хүн ам илүү хурдацтай өсч байна вэ гэдэг нь хамгийн чухал. Төрөлтийн бууралтын нөлөөгөөр нийт хүн амд насанд хүрсэн хүн амын тоо өсч байгаа нь эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, "хүн ам зүйн шилжилтийн нөлөөгөөр хүүхэд залуучуудын ачаалал багаснаар ажиллах хүч огцом өсч, эдийн засгийн хөгжлийн нийтийг хамарсан, нэг удаагийн үсрэлт гардаг хүн ам зүйн урамшуулал буюу түлхэц"-ийг бий болгодог. Иймд хүн ам зүйн чухал элемент нь хүн амын нийт тоо биш харин насны бүтэц гэж ойлгож болохоор байна. Өөрөөр хэлбэл, улс орны хүн амын насны бүтэц нь нийгмийн өөрчлөлтийн гол өдөөгч болж байна.

Монгол улсын хүн амын насны бүтцийн өнгөрсөн, одоо, ойрын ирээдүйн төлөв байдлыг Зураг 1-д харуулав. Монгол улсын хүн ам зүйн нөхцөл байдлаас үүдэн сүүлийн арав гаруй жилийн хугацаанд хүн амын бүтэц, бүрэлдэхүүн нэлээд өөрчлөгдсөн байна. Хүн ам ерөнхийдөө залуу насны бүтэцтэй байснаа идэрших бүтэц рүү шилжиж байгаа бөгөөд хүн ам зүйн урамшуулал нэгэнт болсон байна. Төрөлтийн түвшний бууралтаас үүдэн нийт хүн амд хүүхэд насны хүн амын эзлэх хувийн жин буурч, хөдөлмөрийн насны хүн ам илүү хурдацтай өсч байна. Төрөлтийн огцом бууралтын үр дагавраар хүн амын насны бүтэц нэлээд өөрчлөгдөж байгаа ч хүн амын хөгшрөлт хөгжингүй орнууд дахь хөгшрөлтийн түвшинтэй харьцуулахад тийм их биш байгаа ч гэсэн илүү хурдацтай явагдах төлөвтэй байна.

Зураг 1. Монгол Улсын Хүн амын нас-хүйсийн суварга, сонгосон оноор

¹ Хүн ам зүйн шилжилтийн онол нь хүн амын өсөлтийг хөгжлийн түвшинтэй холбон судлахад ихээхэн ач холбогдолтой юм. Уг онолоор шилжилтийн эхний үед байгаа улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжил маш доогуур, энэ нь төрөлт болон нас баралтын түвшинг өндөр байлгах гол хүчин зүйл болдог гэж тайлбарладаг. Харин улс орны хөгжлийн түвшин дээшлэхийн хэрээр нас баралт, улмаар төрөлт буурч, шилжилтийн дараагийн шатанд шилждэг. Шилжилтийн сүүлийн шатанд төрөлт, нас баралтын түвшин аль аль нь маш доогуур түвшинд хүрдэг.

1990 он 2004 он



Эх үүсвэр: ҮСГ. "Монгол улс зах зээлд" статистикийн эмхтгэл-2003, Монгол Улсын Статистикийн эмхтгэл-2004, Хүн ам, орон сууцны улсын тооллого-2000: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар Иймд бид хүн амын тоонд илүү ач холбогдол өгөх үү эсвэл нэгэнт бий болоод хүн амынхаа бүтэцэд түлхүү ач холбогдол өгөх үү? Хариултын гол нь улс орны эдийн засгийн бодит нөхцөл байдлыг илүү харсан оновчтой сонголт байх юм.

Жулиан Саймон эдийн засгийн ахиц гаргахад "хамгийн хэрэгтэй нөөц" бол хүн амын өсөлт бөгөөд байгалийн хязгаарлагдмал нөөцийг технологийн хөгжлөөр орлуулж болох ба энд хамгийн гол нь хүний өөрийн чадавхи, чадвар, бүтээлч байдал илүү чухал гэсэн санааг 1980-аад онд дэвшүүлж байжээ. Тэрээр хүн амын дунд зэргийн хурдтай өсөлт (хурдан эсвэл хэт удаан гэхээсээ илүү) хүмүүн капиталыг нэмэгдүүлэхэд хамгийн тохиромжтой бөгөөд энэхүү өсөлт нь эдийн

засагт ашигтай байхын тулд хүмүүс өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх, бүтээлч байх боломжийг бүрдүүлсэн орчинд явагдах ёстой гэсэн таамаглалыг тавьжээ (IIPS, Indai, 2002). Түүний энэ санаа нь өнөөдөр хүний хөгжлийн үзэл баримтлалын үндсэн зарчмуудын нэг болох хүний бүтээлч байдлыг дэмжих, нэмэгдүүлэх асуудлыг агуулж байна. Тодруулбал, хүмүүсийн чадавхийг бий болгох, хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулж улмаар бүтээлч чадварыг нь хамгийн дээд хэмжээгээр ашиглах макро эдийн засгийн орчинг бий болгох тухай асуудал юм. Ийм болохоор эдийн засгийн өсөлт нь хүний хөгжлийн загварын нэгэн чухал хэсэг болохоос үндсэн зарчим нь биш юм. Хүний хөгжлийн үзэл баримтлалын үүднээс хөрөнгө оруулалтыг авч үзвэл дан ганц капиталгаар тухайлбал машин механизм, байшин барилга, үйлдвэрлэлийн технологи, эсвэл маш сайн зам, холбоо харилцааны сүлжээ зэрэг дэд бүтэц байгуулахад зарцуулах мөнгө гэж үзэж болохгүй юм. Энэ нь боловсрол, эрүүл мэнд гэх мэт хүмүүн капитал буюу мэдлэг хуримтлуулж чадваржих, бүтээлч байж уг чадвараа ашиглах чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалтыг ч мөн багтаадаг.

Ерөнхийдөө, хүн амын өсөлтийн ерөнхий түвшин нь эдийн засгийн хөгжилд аль нэг насны бүлгийн өсөлтийн түвшнээс бага нөлөө үзүүлдэг ажээ. Бусад насны бүлгийн хүмүүстэй харьцуулахад залуу хүмүүсийн тоо өсөх, ялангуяа, төрөлт буурах үйл явц нь аажим биш, огцом тохиолдох нь эдийн засагт илүү ашигтай байна. Мэдээж хүн ам зүйн өөрчлөлт нь эдийн засгийн хөгжлийн цорын ганц хувьсагч биш нь ойлгомжтой. Хувь хүний эрх чөлөө, хувийн өмчийн эрх, чөлөөт зах зээл, ардчилсан засгийн газар нь тухайн улс орон хөгжиж, эдийн засгийн өндөр түвшинд хүрэх үү, эсвэл энэ түвшиндээ саатаж, эдийн засгийн хувьд зогсонги байдалд орох уу гэдэгт чухал нөлөөтэйг олон улсын туулж өнгөрөөсөн түүхэн туршлага харуулсаар байна.

Иймд юуны өмнө хүн амын тооны асуудлаас илүүтэй чанарын асуудалд онцгой анхаарч, ажиллах хүчний өнөөгийн болон ирээдүйн хандлагыг ухаалгаар хүлээн авч тэднийг шингээх үр дүнтэй ажил эрхлэлтийг дэмжихэд хангалттай хөрөнгө оруулалт хийхэд Засгийн газар хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна. *Эцэст нь дүгнэхэд*, улс үндэсний аюулгүй байдал тусгаар тогтнол, эдийн засгийн хөгжилд хүн амын тоон хэмжээ чухал боловч бид хүн амын бүтцийн өнөөгийн дүр төрхийг оновчтой ашиглах нь хөгжлийн гол түлхүүр байх болно.

Ашигласан материал

1. Micheal P. Todaro, 1992. "Economic Development in the Third World"
2. MPS, IIPS, 2000. "Population and Development: Linkages", Series materials
3. Weeks Jonh. *An introduction to Concepts and Issues*, 2002

4. ХАССТ, НҮБХАС, 2001. *Хүн ам ба хөгжлийн зарчмууд*, орч. ХАССТ
5. David Lucas, Paul Meyer, 1994. *Beginning of population studies*,
6. Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар, 2002. "Хүн ам орон сууцны тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, сэдэвчилсэн судалгаа", Улаанбаатар
7. НХХЯ, ХАССТ, НҮБХХ, 2004. *Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн*, судалгааны тайлан, Улаанбаатар
8. Монголын хүн ам ба хөгжил нийгэмлэг, Хүн амын сургалт, судалгааны төв, НҮБ-ын ХАС, 2004. *Монголын хүн амын нас хүйсийн бүтцийн өнөөгийн ба ирээдүйн хандлага*, Монголын хүн амын сэтгүүл, дугаар 10, Улаанбаатар